



БНМАУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1991 оны 6 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 115
Улаанбаатар хот

БНМАУ-ЫН ХҮН АМ ЗҮЙН ТАЛААР БАРИМТЛАХ ЧИГЛЭЛИЙГ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

- 1."БНМАУ-ын хүн ам зүйн талаар баримтлах чиглэл"ийг зүйтэй гэж үзсүгэй.
- 2.Хүн ам зүйн талаар баримтлах чиглэлийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан нийгэм, эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авахыгБНМАУ-ын засгийн газарт даалгасугай.
- 3.Хүн бүр овог удмаа мэдэж, угийн бичгээ хөтлөх үндэсний түүхэн уламжлалыг сэргээн хөгжүүлэхийг монголын нийт иргэдэд уриалсугай.

БНМАУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П.ОЧИРБАТ